


МӨНГӨНИЙ ТОЙМ

/2014 оны 5 дугаар сар/



МӨНГӨ, САНХҮҮГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2014							
	10-р сар	11-р сар	12-р сар	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар
Инфляци								
Улаанбаатар хотын инфляци								
сарын	1.3	1.3	1.8	1.7	1.0	0.5	0.8	1.3
оны эхнээс	9.0	10.3	12.3	1.7	2.8	3.3	4.1	5.5
жилийн	9.5	11.1	12.3	12.2	12.0	11.9	12.0	13.9
Суурь инфляци								
сарын	2.8	1.2	1.3	0.7	0.3	0.2	0.7	0.8
оны эхнээс	9.4	10.7	12.1	0.7	1.0	1.2	1.9	2.7
жилийн	9.4	11.0	12.1	12.6	13.1	12.6	13.1	14.8
Улсын инфляци								
сарын	1.4	1.3	1.3	1.7	0.9	0.8	1.0	1.5
оны эхнээс	9.7	11.1	12.5	1.7	2.7	3.5	4.6	6.2
жилийн	10.8	12.0	12.5	12.3	12.2	12.4	12.3	13.7
M2 мөнгө, тэрбум төгрөгөөр								
сарын өөрчлөлт, %	8 715.9	9 101.4	9 451.0	10 027.9	9 847.8	9 949.4	10 203.3	10 240.5
жилийн өөрчлөлт, %	2.8	4.4	3.8	6.0	-1.8	1.0	2.6	0.4
Бараг мөнгө, тэрбум төгрөгөөр								
сарын өөрчлөлт, %	6 777.7	7 274.5	7 367.6	8 064.6	8 092.6	8 212.1	8 357.6	8 414.2
жилийн өөрчлөлт, %	4.8	7.3	1.3	9.5	0.3	1.5	1.8	0.7
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, тэрбум төгрөгөөр								
сарын өөрчлөлт, %	22.0	32.8	27.5	40.0	40.6	43.8	51.5	37.3
жилийн өөрчлөлт, %	824.8	803.9	841.1	894.3	756.6	801.2	841.6	863.0
сарын өөрчлөлт, %	-5.7	-2.5	4.6	6.3	-15.4	5.9	5.0	2.5
жилийн өөрчлөлт, %	14.9	11.3	1.5	20.5	12.0	16.5	10.8	3.9
Нөөц мөнгө, тэрбум төгрөгөөр								
сарын өөрчлөлт, %	2 643.7	2 823.2	3 335.6	2 957.5	3 131.1	3 127.5	2 598.8	3 007.8
жилийн өөрчлөлт, %	-10.2	6.8	18.1	2.3	5.9	-0.1	-16.9	15.7
Зээлийн үлдэгдэл, тэрбум төгрөгөөр								
сарын өөрчлөлт, %	23.1	26.9	54.0	54.3	37.9	26.7	4.0	7.4
жилийн өөрчлөлт, %	10 488.8	10 822.4	10 769.3	11 014.9	11 153.9	11 380.9	11 737.7	12 064.9
сарын өөрчлөлт, %	3.3	3.2	-0.5	2.3	1.3	2.0	3.1	2.8
жилийн өөрчлөлт, %	53.0	57.6	54.1	54.3	55.6	54.0	51.0	46.7
Чанаргүй зээл/Нийт зээл, хувиар								
Чанаргүй зээл/Нийт зээл, хувиар (Анод, Зоос-ыг хассанаар)	5.34	5.29	5.26	5.28	5.36	5.22	5.25	5.14
Хуу								
Хадгаламжийн ЖДХ	2.44	2.48	2.48	2.56	2.65	2.57	2.68	2.68
Зээлийн ЖДХ*	12.2	12.3	12.1	12.2	12.2	12.2	12.2	12.2
Монголбанкны ҮТХ зээлийг оруулсан ЖДХ*	18.8	17.3	17.4	18.9	18.4	19.7	19.4	19.1
Ипотекийн зээлийн ЖДХ	16.0	15.7	14.9	17.0	16.4	17.8	17.6	17.2
ТБҮЦ-ны ЖДХ	9.60	9.70	9.90	9.79	9.90	9.90	9.80	10.0
Бодлогын хүү	10.5	10.5	10.5	10.5	10.6	10.6	10.6	10.6
БХЗ-ын ЖДХ	10.50	10.50	10.50	10.50	10.50	10.50	10.50	10.50
	9.64	9.13	8.91	9.48	9.78	9.35	9.58	10.28

* Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

Инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс 2014 оны 5 дугаар сарын эцэст өмнөх сараас 1.5 хувь, оны эхнээс 6.2 хувь, өмнөх оны мөн үеэс 13.7 хувь, Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс өмнөх сараас 1.3 хувь, оны эхнээс 5.5 хувь, өмнөх оны мөн үеэс 13.9 хувиар тус тус өслөө. Суурь инфляци сарын 0.8 хувь, оны эхнээс 2.7 хувь, жилийн 14.8 хувь байв.

Тухайн сард талх, гурил, будааны үнэ 2 хувь, мах, махан бүтээгдэхүүний үнэ 3.9 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ 2.4 хувь, бусад хүнснийх 1.0 хувь, хүнсний ногоо 0.4 хувиар өссөнөөр хүнсний барааны бүлгийн үнэ 2.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Харин хүнснээс бусад бараа, үйлчилгээний үнэ 0.7 хувиар өссөн бөгөөд үүнээс согтууруулах ундаа, тамхины үнэ 1.1 хувь, хувцас, бөс бараа, гуталны бүлэг үнэ 0.9 хувь, эмнэлэгийн амбулторын үйлчилгээний үнэ 6.3 хувь, орон сууцны засварын барилгын материалын (будаг, шал, плита, цемент) үнэ 0.4 хувь, тээврийн бүлэг 0.9 хувь, нийтийн хоолны үйлчилгээ 2.5 хувиар өссөн байна. Сарын инфляцийн 60.5 хувийг хүнсний бараа (үүнээс, талх, гурил, будаа 18.5 хувь, мах 71.1 хувь, сүү, өндөг 11 хувь), 4 хувийг согтууруулах ундаа, тамхи, 9.3 хувийг хувцас, бөс бараа, гутал, 8.2 хувийг тээвэр, 3.8 хувийг эмнэлэгийн үйлчилгээ, 7.1 хувийг нийтийн хоолны үйлчилгээний үнийн өсөлт бий болгожээ.



Тухайн сард нийт хэрэглээний сагсыг бүрдүүлж буй 329 бараа үйлчилгээнээс 125 бараа үйлчилгээний үнэ нь өсч, 88 бараа үйлчилгээнийх буурсан байна.


Жилийн инфляцид хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 11.7 хувь (жилийн өсөлтийн 28 хувь), согтууруулах ундаа, тамхи 16.1 хувь, хувцас, бөс бараа, гутал 16.7 хувь (жилийн өсөлтийн 15.2 хувь), боловсролын үйлчилгээ 28.4 хувь (жилийн өсөлтийн 12.1 хувь), орон сууц, ус, цахилгаан, түлш 17.3 хувь (жилийн өсөлтийн 15.6 хувь), гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа 22.4 хувь (жилийн өсөлтийн 4.9 хувь), эм, тариа, эмнэлэгийн үйлчилгээ 18 хувь (жилийн өсөлтийн 3.6 хувь), тээвэр 5.7 хувь (жилийн өсөлтийн 4.9 хувь), зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 16.2 хувь (жилийн өсөлтийн 4.3 хувь), бусад бараа үйлчилгээ 26.1 хувиар (жилийн өсөлтийн 6.3 хувь) тус тус өссөн байна. Харин амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний үнэ 0.9 хувиар буурсан байна. Хүнсний барааны бүлгийн жилийн өсөлтийн 30 хувийг талх, гурилан бүтээгдэхүүн, 30.2 хувийг мах, махан

бүтээгдэхүүн, 30.2 хувийг өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүний үнийн өсөлт бүрдүүлсэн байна.

Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас 0.4 хувь, оны эхнээс 8.3 хувь, өмнөх оны мөн үеэс 29.5 хувиар өсч 10240.5 тэрбум төгрөгт хүрчээ.

Мөнгөний нийлүүлэлтийн 56.0 хувийг төгрөгийн хадгаламж, 13.7 хувийг валютын хадгаламж, 12.0 хувийг төгрөгийн харилцах, 12.5 хувийг валютын харилцах, 5.8 хувийг хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө эзэлж байна.



Ипотекийн хөтөлбөрийг мөнгөний нийлүүлэлтээс хасч тооцвол мөнгөний нийлүүлэлт 9.0-29.5 хувийн хооронд өсөхөөр байв.



Тайлант сард мөнгөний үзүүлэлтүүдийн жилийн өсөлтийн хурд бүгд саарсан байна. Үүнд, төгрөгийн хадгаламжийн жилийн өсөлтийн хурд өмнөх сарынхаас 11.2 нэгж хувь, төгрөгийн харилцахынх 6.2 нэгж хувь, гадаад валютын хадгаламжийнх 23.1 нэгж хувь, гадаад валютын харилцахынх 13.8 нэгж, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгөнийх 11.5 нэгж хувиар буурсан байна.


Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлтийг авч үзвэл гадаад валютын харилцах 111.5 тэрбум төгрөг, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 4.8 тэрбум төгрөгөөр өссөн бол төгрөгийн хадгаламж 6.9 тэрбум төгрөг, төгрөгийн харилцах 24.2 тэрбум төгрөг, гадаад валютын хадгаламж 48.1 тэрбум төгрөгөөр буурчээ.



Нийт мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн 76.5 хувийг төгрөгийн хадгаламж, 12.3 хувийг гадаад валютын харилцах, 9.2 хувийг гадаад валютын хадгаламж, 2.1 хувийг төгрөгийн харилцах, -0.1 хувийг хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө тус тус бүрдүүлсэн байна.

Хадгаламж

Нийт хадгаламж өмнөх сараас 0.8 хувь буюу 55.0 тэрбум төгрөгөөр буурч, өнгөрсөн оны мөн үеэс 38.9 хувь буюу 1998.8 тэрбум төгрөгөөр өсч 7137.8 тэрбум төгрөг болов.



Аж ахуйн нэгж, байгууллагуудын төгрөгийн хадгаламж өмнөх сараас 0.6 хувь буюу 11.6 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 3.2 дахин их буюу 1422.1 тэрбум төгрөгөөр өсч 2079.4 тэрбум төгрөг болсон бол иргэдийн төгрөгийн хадгаламж өмнөх сараас 0.5 хувь буюу 18.4 тэрбум төгрөгөөр буурч, харин өнгөрсөн оны мөн үеэс 11.0 хувь буюу 361.9 тэрбум төгрөгөөр өсч 3653.7 тэрбум төгрөгт хүрчээ. Гадаад валютын хадгаламж өмнөх сараас 3.3 хувь буюу 48.1 тэрбум төгрөгөөр буурсан бол өнгөрсөн оны мөн үеэс 18.0 хувь буюу 214.7 тэрбум төгрөгөөр өсч 1404.7 тэрбум төгрөг болжээ.




Нийт хадгаламжийн 80.3 хувь нь төгрөгийн, 19.7 хувь нь валютын хадгаламж байгаа бөгөөд төгрөгийн хадгаламжийн нийт хадгаламжинд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 3.5 нэгж хувиар өссөн байна.

Гадаад, дотоод цэвэр актив


Гадаад цэвэр актив өмнөх сараас 143.5 хувь, өмнөх оны мөн үеэс 104.5 хувиар буурснаар -144.5 тэрбум төгрөгт, дотоод цэвэр актив

өмнөх сараас 5.2 хувь, өмнөх оны мөн үеэс 2.2 дахин их өсч 10385.0 тэрбум төгрөг болов.



Нөөц мөнгө

Нөөц мөнгө өмнөх сараас 15.7 хувь, өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар өсч 3007.8 тэрбум төгрөгт хүрэв. Тайлант сард хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 0.8 хувь буюу 4.8 тэрбум төгрөг, банкуудын касс 6.7 хувь буюу 16.5 тэрбум төгрөг, Төв банк дахь харилцах, хадгаламж 22.0 хувь буюу 387.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.



Банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар өсч 71.4 хувь болсон бол, банкуудын кассын эзлэх хувь 0.5 нэгж хувиар өсч 8.8 хувь, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгөнийх 1.5 нэгж хувиар буурч 19.8 хувь болсон байна.

Зээл

Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд саарч өмнөх сараас 4.4 нэгж хувиар буурчээ.

Хадгаламжийн байгууллагуудаас¹ олгосон зээл өмнөх сарынхаас 2.8 хувь буюу 327.2 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 46.7 хувь буюу 3838.5 тэрбум төгрөгөөр өсч 12.1 их наяд төгрөгт хүрсэн байна. Хадгаламжийн байгууллагуудаас хувийн хэвшилд олгосон зээл өмнөх сараас 2.3 хувь буюу 149.0 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 45.9 хувь буюу 2064.5 тэрбум төгрөгөөр өсч 6562.7 тэрбум төгрөгт, иргэдэд олгосон зээл өмнөх сараас 3.4 хувь буюу 178.0 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 47.6 хувь буюу 1750.2 тэрбум төгрөгөөр өсч 5423.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.

¹Хадгаламжийн байгууллагад арилжааны банкуудаас гадна мөнгөний нийлүүлэлтийн тооцоонд ордог харилцах, хадгаламж хэлбэрээр бусдаас хөрөнгө

татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллага (Хадгаламж, зээлийн хоршоо) хамрагдана.



Харин 8%-ийн ипотекийн зээлийг хасч тооцвол, иргэдийн зээлийн жилийн өсөлт 2014 оны 5 дугаар сарын байдлаар 3.6 хувь, Монголбанкны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн зээлийг хасч тооцвол хувийн хэвшлийн зээлийн жилийн өсөлт 40.5 хувьтай байхаар байжээ.

Нийт зээлийг өмчлөгчөөр нь авч үзвэл 54.4 хувь нь хувийн хэвшил, 45 хувь нь иргэд, 0.6 хувь нь улсын байгууллага, 0.05 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна.




Нийт зээлийн үлдэгдлийн 91.7 хувийг хэвийн зээл, 3.2 хувийг хугацаа хэтэрсэн

зээл, 5.1 хувийг чанаргүй зээл тус тус эзлэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.3 нэгж хувиар их байна.

Картын зээл

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын банкны картын зээлийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.3 хувийг бүрдүүлж байна.

Картын зээл тайлант сард 275.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 37.6 хувиар буюу 75.2 тэрбум төгрөгөөр өсчээ. Картын зээлийн дийлэнхийг иргэдэд олгосон байгаа бөгөөд иргэдийн картын зээл өмнөх сараас 3.8 хувиар буюу 10.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.



Картын зээлийн 95.9 хувь нь хэвийн, 1.5 хувь нь хугацаа хэтэрсэн, 2.6 хувь нь чанаргүй гэж ангилагджээ. Картын зээлийн 95.4 хувь нь төгрөгөөр, 4.6 хувь нь валютаар олгогдсон байна.

Хүү

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 2014 оны 5 дугаар сард өнгөрсөн оны мөн үеэс 1.5 нэгж хувиар буурч жилийн 10.56 хувь болов. Банкуудын тухайн сард олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү² өнгөрсөн оны мөн үеэс 0.6 нэгж хувиар өсч жилийн 19.1 хувь, гадаад валютынх өнгөрсөн оны мөн үеэс 1.1 нэгж хувиар буурч жилийн 12.1 хувь болжээ.




Харилцахын жигнэсэн дундаж хүү өөрчлөлт багатай байгаа бөгөөд төгрөгийн харилцахын жигнэсэн дундаж хүү жилийн 2.7 хувь, валютынх жилийн 1.7 хувьтай байна. Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс өөрчлөлтгүй байгаа бөгөөд жилийн 12.2 хувь, валютын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 0.2 нэгж хувиар өсч жилийн 5.6 хувь болов.

² Банкуудын тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү нь Монголбанкны ҮТХ-ийн зээлийг оруулахгүй тооцсон хүү болно. Харин үнэ тогтворжуулах

Мөнгөний зах

2014 оны 5 дугаар сард банк хоорондын захын арилжаагаар нийт 898.1 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 10.28 хувь байна.



2014 оны 4 сарын 30-ны өдрөөс 5 сарын 27-ний өдрийн хугацаанд банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд 914.2 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөд 379.1 тэрбум төгрөг байлгах шаардлагыг хангаж ажиллав. Банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд 916.5 тэрбум төгрөг, валютын нөөцөд 1063.9 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

Валютын ханш

Төгрөгийн ам. доллартай харьцах ханш 2014 оны 5 дугаар сарын эцэст 1818.65 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 376.5 төгрөгөөр суларсан байна. Тайлант сард төгрөгийн ам.

хөтөлбөрийн зээлийг оруулан тооцвол төгрөгийн жигнэсэн дундаж хүү тайлант сард 17.2 хувь байна.

доллартай харьцах дундаж ханш 1813.08
төгрөг байв.

